



## БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын  
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн  
аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** БУА-2026/35/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

Булган аймаг  
2026 он

Булган аймаг дахь төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Д.Батцогт  
Утас: 7034-2580 Цахим хаяг: [Battsogtd@audit.gov.mn](mailto:Battsogtd@audit.gov.mn)

Аудитын менежер: Ж.Энхцоодол  
Цахим хаяг: [Enkhtsoodolj@audit.gov.mn](mailto:Enkhtsoodolj@audit.gov.mn)

Ахлах аудитор: Д.Анхбаяр  
Цахим хаяг: [Ankhubayard@audit.gov.mn](mailto:Ankhubayard@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Нэг. Аудитын санал дүгнэлт



### БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,  
63082, Утас/Факс: 7034-2580  
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2026.02.24 № 137

танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙН  
ХӨГЖИЛ, ХАМГААЛЛЫН ГАЗРЫН  
ДАРГА С.ОЮУНЗАЯА ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон тэмдэглэсэн хэсэг

Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх танхимаар 351 хүнд үйлчилсэн нь өнгөрсөн оноос 2 дахин, 96100108 тусгай утсаар зөвлөгөө авсан иргэдийн тоо 4.3 дахин, ганцаарчилсан зөвлөгөө авсан насанд хүрэгчийн тоо 8.8 дахин өссөн үр дүн гарсан байна. Насанд хүрэгчдийн зөвлөгөө авч буй гол сэдэв нь гэр бүлийн харилцаа болон хүүхдийн хүмүүжүүлж байгаа нь гэр бүлд чиглэсэн зөвлөгөө, үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн үр дүнтэй байна. Энэ онд нийт 6841 хүнийг гэр бүлийн боловсрол олгох сургалт нөлөөллийн үйл ажиллагаанд хамруулсан нь зорилтот түвшинээс 1841 хүн буюу 36,8% илүү хангагдсан байна.

Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилт, 44 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 96.4 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

### Аудитын гол асуудал

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлага Хүүхэд, гэр бүлийн хөгжил,

5326050089

хамгааллын ерөнхий газрын даргын 2022 оны А/188 тушаалаар Булган аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газрын орон тоог удирдлага 1, мэргэжилтэн 17, туслах ажилтан 9 гэсэн зохион байгуулалттайгаар баталсан байна.

#### **Бусад асуудал**

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТЦОГТ

## Хоёр. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

(мянган төгрөгөөр)

|  | Үзүүлэлт  | 2024.12.31.        | 2025.12.31.         |
|--|---|--------------------|---------------------|
| <b>Санхүүгийн байдлын тайлан</b>               |   |                    |                     |
|  | Эргэлтийн хөрөнгийн дүн                           | 16,331.5           | 33,161.49           |
|  | Эргэлтийн бус хөрөнгийн дүн                       | 506,559.06         | 523,266.47          |
|  | <b>Нийт хөрөнгийн дүн</b>                         | <b>522,890.56</b>  | <b>556,427.96</b>   |
|  | Нийт өр төлбөрийн дүн                             | -                  | -                   |
|  | Цэвэр хөрөнгө/өмчийн дүн                          | 522,890.56         | 556,427.96          |
|  | <b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>        | <b>522,890.56</b>  | <b>556,427.96</b>   |
| <b>Санхүүгийн үр дүнгийн тайлан</b>            |   |                    |                     |
|  | Үйл ажиллагааны орлогын дүн                       | 1,223,884.81       | 2,028,186.10        |
|  | Үйл ажиллагааны зардлын дүн                       | 1,181,507.91       | 1,971,726.01        |
|  | <b>Үйл ажиллагааны үр дүн</b>                     | <b>272.81</b>      | <b>-</b>            |
|  | Үйл ажиллагааны бус үр дүн                        | (272.81)           | -                   |
|  | <b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>                | <b>45,639.94</b>   | <b>33,537.40</b>    |
| <b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b> |   |                    |                     |
|  | Дахин илэрхийлсэн үлдэгдэл                        | 453,322.06         | 552,890.56          |
|  | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт           | 23,928.55          |                     |
|  | Тайлант оны үр дүн                                | (45,639.94)        | (33,537.40)         |
|  | <b>Эцсийн үлдэгдэл</b>                            | <b>552,890.56</b>  | <b>556,427.96</b>   |
| <b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>                |   |                    |                     |
|  | Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн                | 1,181,507.91       | 1,971,726.01        |
|  | Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн               | 1,138,923.91       | 1,940,266.01        |
|  | <b>Үйл ажиллагааны ЦМГ</b>                        | <b>42,584.00</b>   | <b>31,460.00</b>    |
|  | <b>Хөрөнгө оруулалтын ЦМГ</b>                     | <b>(42,584.00)</b> | <b>(31,460.00)</b>  |
|  | <b>Санхүүгийн ажиллагааны ЦМГ</b>                 | <b>-</b>           | <b>-</b>            |
|  | <b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>                  | <b>-</b>           | <b>-</b>            |
|  | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл  | -                  | -                   |
|  | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | -                  | -                   |
| <b>Төсвийн гүйцэтгэлийн тайлан</b>             |   |                    |                     |
|  | <b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>          | <b>-</b>           | <b>1,686,042.87</b> |
|  | Урсгал зардал                                     | -                  | 1,686,042.87        |
|  | Хөрөнгийн зардал                                  | -                  | -                   |
|  | <b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>             | <b>-</b>           | <b>1,818,059.70</b> |
|  | Улсын төсвөөс санхүүжих                           | -                  | 1,818,059.70        |
|  | Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас             | -                  | -                   |

### Гурав. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар /цаашид ХГБХХГ/ нь “Тогтвортой, аз жаргалтай, ирээдүйд итгэлтэй хүүхэд, гэр бүлийг төлөвшүүлэх, хөгжүүлэх, тэдний эрхийг хамгаалахад оршино” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулжээ.

### Байгууллагын гадаад, дотоод орчин

Тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд Гэр бүлийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Залуучуудын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Шилэн дансны хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль болон бусад хууль, тогтоомжууд, эрх зүйн актуудыг мөрдлөг болгон ажилласан байна.

Тайлант хугацаанд Төсвийн тухай хуульд 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

ХГБХХГ нь Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн ерөнхий газрын даргын 2021 оны А/02 дугаар тушаалаар баталсан НББ-ийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### **Дөрөв. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх танхимаар 351 хүнд үйлчилсэн нь өнгөрсөн оноос 2 дахин, 96100108 утсаар зөвлөгөө авсан иргэдийн тоо 4.3 дахин, ганцаарчилсан зөвлөгөө авсан насанд хүрэгчийн тоо 8.8 дахин өссөн үр дүн гарсан байна. Насанд хүрэгчдийн зөвлөгөө авч буй гол сэдэв нь гэр бүлийн харилцаа болон хүүхдийн хүмүүжил байгаа нь гэр бүлд чиглэсэн зөвлөгөө үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн үр дүнтэй байна. Энэ онд нийт 6841 хүнийг гэр бүлийн боловсрол олгох сургалт нөлөөллийн үйл ажиллагаанд хамруулсан нь зорилтот түвшинээс 1841 хүн буюу 36,8% илүү хангагдсан байна.

Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилт, 44 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 96.4 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

### **Тав. Аудитын гол асуудал**

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлага Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын даргын 2022 оны А/188 тушаалаар Булган аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газрын орон тоог удирдлага 1, мэргэжилтэн 17, туслах ажилтан 9 гэсэн зохион байгуулалттайгаар баталсан байна.

### **Зургаа. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

#### **Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тухайн байгууллага 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтууд, 15 дугаар зүйлийн 15.1.2-15.1.7 дахь заалтуудад заасан хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалтыг хэрэгжүүлээгүй, цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй байна.

#### **Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### **Долоо. Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Аудитын гүйцэтгэх цаг хугацааны нөөц, цар хүрээ хязгаарлагдмал байсан учраас дараагийн аудитаар бараа материалын орлого, зарлагыг хууль, тогтоомжийн дагуу тухай бүр нь анхан шатны бүртгэл хөтлөж ажилласан эсэхийг анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## Найм. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 58,319.8 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 1,000.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 57,319.8 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгч ажиллалаа.

### Төлбөрийн акт

1. Хүүхдийн байгууллагын 100 жилийн ойгоор 3-н үеийн уулзалтын ТВ нэвтрүүлэг хийсэн нь ТХТХ-ийн 15 дугаар зүйлийн 15.1.4-д "Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх" гэсэн заалт, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Хууль, тогтоомж зөрчиж зарцуулсан 1,000.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

### Албан шаардлага

Албан шаардлага өгөөгүй.

### Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

*Илрүүлэлт:* Бараа материалыг хэрэгцээ шаардлагатай үед нь бодитоор зарлагдаагүй худалдан авсан дүнгээр бөөнд нь хий зарлагдаж анхан шатны бүртгэлийг буруу гаргасан байна. Үүнд: Хүүхдийн зуслангийн үйл ажилагааны хүнсний материал 41.92, тээвэр шатахуун 4.6 сая төгрөг, ахуй, ариун цэврийн хэрэгсэл 2.5 сая төгрөг байна.

*Өгсөн зөвлөмж:* Зөрчлийг давтан гаргахгүй байх

2. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

*Илрүүлэлт:* Худалдан авах бараа үйлчилгээний жагсаалт, холбогдох бараа үйлчилгээг цахим дэлгүүрт оруулж худалдан авалт хийгээгүй компьютер, техник хэрэгсэл, тавилга, ширээ, сандал худалдан авсан.

*Өгсөн зөвлөмж:* Зөрчлийг давтан гаргахгүй байх

3. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал

*Илрүүлэлт:* Нийгмийн даатгалын шимтгэлд илүү шилжүүлсэн авлага 142.5, шугам хоолой хөлдөлтийг засварлах ажлын хөлсний өглөг 2,392.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

*Өгсөн зөвлөмж:* Авлага болон өр төлбөрийг барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 06 дугаар сарын 10-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

(мянган төгрөгөөр)

| Зөрчлийн товч утга  | Нийт зөрчил |                 | Үүнээс        |     |                 |     |          |                 |                                      |          |   |          |          |          |
|---|-------------|-----------------|---------------|-----|-----------------|-----|----------|-----------------|--------------------------------------|----------|---|----------|----------|----------|
|   |             |                 | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |     | Зөвлөмж  |                 | Хариуцлага тооцуулах албан шаардлага |          | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |          |          |          |
|   | Тоо         | Дүн             | Тоо           | Дүн | Тоо             | Дүн | Тоо      | Дүн             | Тоо                                  | А.Т тоо  | Тоо   | Дүн      |          |          |
| Бараа материалыг хэрэгцээ шаардлагатай үед нь бодитоор зарлагдаагүй худалдан авсан дүнгээр бөөнд нь хий зарлагдаж анхан шатны бүртгэлийг буруу гаргасан байна. Үүнд: Хүүхдийн зуслангийн үйл ажиллагааны хүнсний материал 41.92, тээвэр шатахуун 4.6 сая төгрөг, ахуй, ариун цэврийн хэрэгсэл 2.5 сая төгрөг байна. | 1           | 49,025.0        |               |     |                 |     | 1        | 49,025.0        |                                      |          |   |          |          |          |
| Нийгмийн даатгалын шимтгэлд илүү шилжүүлсэн авлага 142.5, шугам хоолой хөлдөлтийг засварлах ажлын хөлсний өглөг 2,392.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.  | 1           | 2,534.8         |               |     |                 |     | 1        | 2,534.8         |                                      |          |   |          |          |          |
| <b>Дүн</b>  | <b>2</b>    | <b>51,559.8</b> |               |     |                 |     | <b>2</b> | <b>51,559.8</b> | <b>-</b>                             | <b>-</b> | <b>-</b>  | <b>-</b> | <b>-</b> | <b>-</b> |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

(мянган төгрөгөөр)

| Зөрчлийн товч утга   | Нийт зөрчил |          | Үүнээс        |         |                 |     |         |         |
|--|-------------|----------|---------------|---------|-----------------|-----|---------|---------|
|  |             |          | Төлбөрийн акт |         | Албан шаардлага |     | Зөвлөмж |         |
|  | Тоо         | Дүн      | Тоо           | Дүн     | Тоо             | Дүн | Тоо     | Дүн     |
| Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил   |             |          |               |         |                 |     |         |         |
| Худалдан авах бараа үйлчилгээний жагсаалт, холбогдох бараа үйлчилгээг цахим дэлгүүрт оруулж худалдан авалт хийгээгүй компьютер, техник хэрэгсэл, тавилга, ширээ, сандал худалдан авсан | 1           | 5,760.0  |               |         |                 |     | 1       | 5,760.0 |
| Хүүхдийн байгууллагын 100 жилийн ойгоор 3-н үеийн уулзалтын TV нэвтрүүлэг хийсэн   | 1           | 1,000.0  | 1             | 1,000.0 |                 |     |         |         |
| Дүн  | 2           | 6,760.00 | 1             | 1,000.0 |                 |     | 1       | 5,760.0 |